



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/469

Улаанбаатар хот

「 Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын  
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 24,694,835.3 /хорин дөрвөн сая зургаан зуун ерэн дөрвөн мянга найман зуун гучин таван төгрөг гучин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Донг фенг маркийн 12-95 УБВ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ /Ж.Дагвасүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ /Ж.Дагвасүрэн/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ